



**АТМ-ИЙН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДЫН ХУВЦАС НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: АТМ-ийн инженер техникийн ажилчдын хувцас нийлүүлэх
Харьцуулалт/ ТБ/202001193
гэрээний дугаар:

**Улаанбаатар хот
2020 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Төрийн банк нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос *АТМ-ийн инженер техникийн ажилчдын хувцас нийлүүлэх* тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг *2020 оны 06-р сарын 09-ний өдрийн 11 цаг 00* минутаас өмнө *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д цахим хэлбэрээр* ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан *тухайн өдрийн 11 цаг 10 минутад* нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичгийг *Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс* авна. Утас: 94006266

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |


- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.


Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ



ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал /Үнийн саналын маягтын дагуу ирүүлэх/ 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Байгууллагын тухай танилцуулга 4. Татварын цахим тайлангийн систем (www.e-tax.mta.mn)-ээс авсан татварын тодорхойлолтыг ирүүлэх ба энэхүү тодорхойлолтын хүчинтэй хугацаа нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Монгол Улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна /Тодорхойлолтын доод хэсэгт байрлах баркод болон тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаар гаргацтай байх шаардлагатай/. 5. Барааны талаар дэлгэрэнгүй танилцуулга /Зураг, техник үзүүлэлт ирүүлэх/ 6. Бараа нийлүүлэх хуваарь 7. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ 8. Харилцагч банкны тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ /Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй харилцагч банк болгоноос хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй тухай тодорхойлолт авна/. 9. 2019 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ. /Сангийн яамны И-баланс цахим системд шивэгдэж баталгаажсан тайлан байх/ 10. 2018, 2019 оны аль нэг жилд ижил төстэй бүтээгдэхүүн нийлүүлсэн гэрээний үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. Туршлагын мэдээллийг дэлгэрэнгүй ирүүлнэ. Гэрээ, актыг заавал хавсаргаж ирүүлнэ /Зарлагын баримтыг акт гэж тооцохгүй/. 11. Баталгаат хугацаа 1-2 жил байх. /нотолсон албан тоот ирүүлэх/ 12. Баталгаат хугацаанд нийлүүлсэн бараанд гарсан үйлдвэрлэгч талын аливаа асуудал, гэмтэл, доголдлыг үнэ төлбөргүй сольж өгөх замаар бүрэн шийдвэрлэнэ. /Баталсан албан бичиг ирүүлнэ/ 13. Санал болгож буй барааг санал болгосон үнэдээ багтаан хугацаандаа нийлүүлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ. 14. Төрийн банкны зүгээс тухайн тендерт оролцогчийн харилцагч банк, харьяа татвар, шүүх болон бусад байгууллагад хандаж, түүний талаар тодорхойлолт хүсэхэд татгалзахгүй тухай зөвшөөрсөн албан бичиг 15. Хувилбарт үнийн санал ирүүлэхгүй.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><i>2020 оны 06-р сарын 09-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д цахим хэлбэрээр</i> хүлээн авна.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн цагаар тоологдох, Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ, нэг файлын хэмжээ зэрэг нь хязгаарлагдмал байдаг зэргийг анхаарна уу. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Холбоочдын гудамж, Төрийн банкны төв 2-р байр, 2-р давхар, 202 тоот өрөө. Огноо: 2020 оны 06-р сарын 09-ний өдөр.</p> <p>Цаг: 11 цаг 10 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>


Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. Барааны тодорхойлолт: Нийлүүлэгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурьдсан барааны тодохойлолт, техникийн үзүүлэлтийг хангасан байна.

№	Нэр төрөл	Үзүүлэлт
АТМ-ЫН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДЫНХУВЦАС		
1	ХАГАС ТҮРИЙТЭЙ ГУТАЛ	<p>The 5.11 Tactical norris sneaker эсхүл түүнтэй дүйцэхүйц байх</p> <p>МАТЕРИАЛ: Амьсгалдаг арьс, тусгай даавуун оруулгатай, уландаа хамгаалалттай, хальтирдаггүй ултай</p> <p>ХЭРЭГЛЭЭ -Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, чийг татдаггүй байх шаардлагатай.</p> <p>ТЕХНОЛОГИ</p> <ul style="list-style-type: none"> - Ortholite- Хөлд эвтэйхэн - VIBRAM-Тос, ус үл нэвтрэх бах бөх - ASTM сертификаттай байх <p>УЛ:</p> <ul style="list-style-type: none"> - Халтирдаггүй SRC vibram TPU ул - Тос, ус нэвтрэхгүй - Дуу чимээ гарахгүй, хяхтнахгүй <p>ӨНГӨ:</p> <ul style="list-style-type: none"> - Хар , ногоон болон бусад <p>РАЗМЕР:</p> <ul style="list-style-type: none"> - 38-42 <p>БАТАЛГАА:</p> <ul style="list-style-type: none"> - 2 жил <p>ЗУРАГ:</p> <div style="text-align: center;">  </div>
	ХАВАР НАМРЫН	<p>5.11 tractical Chameleon Softshell Jcaket эсхүл түүнтэй дүйцэхүйц байх</p> <p>МАТЕРИАЛ:</p> <ul style="list-style-type: none"> - Ус нэвтрэхгүй амьсгалдаг 92% полиэстер 8% эластан, <p>ХЭРЭГЛЭЭ:</p> <ul style="list-style-type: none"> - Гадар хүрэм нь салхи, ус нэвтрэхгүй, амьсгалдаг, бат

2	<p>КУРТКА</p>	<p>бөх</p> <ul style="list-style-type: none"> - Ханцуйгаа тохируулж болдог. - Зип цахилгаантай - Трикотын эрүү хамгаалагч - Сунаж агшдаг, салхи нэвтрэх, гулсахаас сэргийлэх ханцуйтай <p>ТЕХНОЛОГИ:</p> <ul style="list-style-type: none"> - MODYTEX - Чийг нэвтрүүлэхгүй, гадагшлуулах - STRETCH -Уян хатан, сунаж агших <p>ӨНГӨ:</p> <ul style="list-style-type: none"> - Хар хөх, саарал <p>РАЗМЕР:</p> <ul style="list-style-type: none"> - S-XXL <p>БАТАЛГАА:</p> <ul style="list-style-type: none"> - 2 жил <p>ЗУРАГ:</p> 
3	<p>ӨМД</p>	<p>5.11 icon pant эсхүл түүнтэй дүйцэхүйц байх</p> <p>МАТЕРИАЛ:</p> <ul style="list-style-type: none"> - 67% полиэстер / 33% хөвөн - Ус үл тогтох - Цуурахгүй <p>ШИНЖ ЧАНАР:</p> <ul style="list-style-type: none"> - Зөөлөн уян хатан даавуун материалтай - Урдаа товчтой - ҮКК цахилгаантай - Арын болон гуяны халаасууд нь таг эсвэл цахилгаантай <p>ТЕХНОЛОГИ:</p> <ul style="list-style-type: none"> - Flex Tag -Уян хатан, сунаж агших - Teflon –тоос үл шингээх <p>РАЗМЕР:</p> <ul style="list-style-type: none"> - S-XXL <p>ӨНГӨ:</p> <ul style="list-style-type: none"> - ШАРГАЛ, ХАР, ХӨХ

		<p>БАТАЛГАА: - 1 жил</p> <p>ЗУРАГ:</p> 
4	<p>ЗАХТАЙ ФУТВОЛКА</p>	<p>5.11 rapid short sleeve polo эсхүл түүнтэй дүйцэхүйц байх МАТЕРИАЛ: - 100% полиэстер—approx. 230g/m2 ШИНЖ ЧАНАР: - Зах хэсгээрээ давхар оёдолтой - Эдэлгээний явцад сунахгүй - Бие барьж хөлөргөхгүй - Үнэр гадагшлуулах материал ТЕХНОЛОГИ: - COMFORT FIT-Биед маш эвтэйхэн - Flex Tag -Уян хатан, сунаж агших ӨНГӨ: - Хар, Саарал, Хөх РАЗМЕР: - XS-XXL БАТАЛГАА: - 1 жил</p> <p>ЗУРАГ:</p> 

5	НООСОН ЦАМЦ	<p>5.11 grapple fleece crew эсхүл түүнтэй дүйцэхүйц байх МАТЕРИАЛ: - 80% хөвөн / 20% полиэстер–дунджаар 140g/m2 ШИНЖ ЧАНАР: - Эдэлгээний явцад сунахгүй - Бие барьж хөлөргөхгүй - Нуруу хэсгээрээ амьсгалдаг ТЕХНОЛОГИ: - COMFORTFIT- биед маш эвтэйхэн ӨНГӨ: - Саарал, Хөх болон бусад РАЗМЕР: - XS-XXL БАТАЛГАА: - 1 жил ЗУРАГ:</p> 
	Тоо ширхэг	Төрөл тус бүрээс 8 ширхэг

- Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
- Баглаа, боодол:** Бараа нь баглаа боодолтой, шинэ байна. Баглаа боодол бүрийн гадна талд бүтээгдэхүүний нэр, тоо ширхэгийг тэмдэглэсэн товъёог наасан байна
- Бараа хүргэх, тогтоон байршуулах газар:**

Барааг захиалагчийн товлосон газар хүргэж төрийн банкны бараа, ажил үйлчилгээ хүлээлцэх актаар хүлээлгэн өгч гарын үсэг тамга тэмдэгээр баталгаажуулна.

4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хагас түрийтэй гутал	Техникийн тодорхой лолт 3-т заагдсаны дагуу	8	ширхэг	Техникийн тодорхойлолт 3-т заагдсаны дагуу	Хуанлийн 10 хоног	Хуанлийн 30 хоног	
Хавар намрын куртка		8	ширхэг				
Өмд		8	ширхэг				
Захтай футболка		8	ширхэг				
Ноосон цамц		8	ширхэг				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Төрийн банкны гүйцэтгэх захирал Ө.Гантөр танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Хагас түрийтэй гутал			8				
Хавар намрын куртка			8				
Өмд			8				
Захтай футболка			8				
Ноосон цамц			8				
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн *[100]*¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²** 9.1. Алданги оногдуулах хувь: *[0,5 хувь]*
- Алдангийн нийт дүн: *[10 хувь]*

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____ (Тамга, тэмдэг)	_____ (Тамга, тэмдэг)
_____ (Гарын үсэг)	_____ (Гарын үсэг)
_____ (Албан тушаал)	_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]